

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Аудитын ГЭРЧИЛГЭЭ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
СБД	Сүхбаатар дүүрэг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТЫН VII, XIV,
МҮОНРТ-ИЙН ХОРООЛЛЫН ОРОН
СУУЦ, ДЭД БҮТЭЦ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Ч.ДОРЖГОТОВ
ТАНАА

᠒᠐᠒᠐.᠐᠒.᠒7 № 06/634
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төсөл нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Ч.Доржготов Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, хөрөнгө бараа материалын тооллогыг цаг хугацаанд нь хийж байх, ХХОАТ-ын тухай хуулийн шинэчлэлийг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.

Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төслийн зохицуулагч санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулга дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ноос 2020 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төслийн зохицуулагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Б энд С аудит ХХК-ийн захирал Д.Дашхорлоо, Чанарын хяналтын менежер Э.Дэлгэрцэцэг, ахлах аудитор Д.Заяажаргал, аудиторын туслах Ц.Дөлгөөн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга тайланг Б энд С аудит ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 2020/01/27/01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Улаанбаатар хотын агаарын болон хөрсний бохирдлыг бууруулах, VII, XIV хорооллыг барилгажуулах эхлэлийг тавих, VII хороолол, МҮОНРТ орчмын хорооллыг инженерийн дэд бүтцэд холбох, цахилгаан хангамжийг сайжруулахад оршино.

Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- 1-р багц ажил: Улаанбаатар хотын VII, XIV хороололд нийт 2592 айлын орон сууц барих,
- 2-р багц ажил: Орон сууцны VII хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэх,
- 3-р багц ажил: МҮОНРТ-ийн орчмын хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэх,
- 4-р багц ажил: Улаанбаатар хотын VII хороолол, МҮОНРТ-ийн орчмын хорооллыг цахилгааны эх үүсвэрээр хангах 23.3 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам болон “Улаанбаатар” дэд станцын өргөтгөл, “7-р хороолол”, “Радио телевиз” дэд станцын угсралтын ажлыг гүйцэтгэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Мэжик финанс” программ хангамж ашигладаг байна.

Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 433,204.8 мянган төгрөгөөс тооцон 8,664.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,389,115.8 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	442,639.1	41,518.7	-401,120.4
Авлага	3,078.4	31,720.4	28,642.0
Урьдчилгаа	11,870,128.0	12,460,965.8	590,837.8
Бараа материал	3,933.6	3,933.6	
Үндсэн хөрөнгө	149,612,735.7	151,783,492.1	2,170,756.4
Нийт хөрөнгө	161,932,514.9	164,321,630.7	2,389,115.8
Өр төлбөр	25,249.5	21,029.4	-3,220.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	161,907,265.3	164,300,601.3	2,393,336.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	161,932,514.9	164,321,630.7	2,389,115.8

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг авч үзвэл авлага дансны үлдэгдэл 28,642.0 мянган төгрөгөөр өссөн нь Сангийн яаманд төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлага 28,060.0 мянган төгрөг, хувь хүнээс авах авлага 507.8 мянган төгрөг, ХХОАТ-ын хөнгөлөлт буруу тооцсоноос СБД-ийн татварын хэлтсээс 74.2 мянган төгрөгийн авлага үүссэн зэргээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2017 онд үүссэн хувь хүнээс авах 2,880.9 мянган төгрөгийн авлага байна. Энэ авлагыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх нь зүйтэй.

Хятадын засгийн газраас гүйцэтгэгч байгууллагад шууд шилжүүлсэн төслийн санхүүжилт 12,460,965.8 мянган төгрөгийг урьдчилгаа дансанд бүртгэсэн байна.

Бараа материал дансанд 2017 онд худалдаж авсан 3,933.6 мянган төгрөгийн хангамжийн материал байгаагаас 1,782.5 мянган төгрөгийн материалыг цаашид ашиглах боломжгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл дуусаагүй барилгын инженерийн шугам сүлжээний ажил 2,194,778.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 08-ны А1\3436 тушаалын дагуу 70,406.2 мянган төгрөгийн үнэтэй 34-66 УНЦ улсын дугаартай Ландкрузер 200 автомашиныг Барилгын хөгжлийн төвд балансаас балансад шилжүүлсэн,

тайлант хугацааны хуримтлагдсан элэгдэл 47,828.3 мянган төгрөгөөр тус тус хөрөнгө буурсан.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь байгууллагад төлөх 4,700.3 мянган төгрөгийн өглөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансанд 2018 онд үүссэн байгууллагад өгөх өглөг 20,549.3 мянган төгрөг, 2019 онд ажилчдын цалин хөлсийг буруу тооцсоноос үүссэн 480.1 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төслийн зохицуулагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төслийн зохицуулагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 406,732.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас цалингийн зардалд 147,320.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 18,415.0 мянга, урсгал зардалд 240,997.5 мянга нийт 406,732.5 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлыг Барилга хот байгуулалтын яамны УБ хотын орон сууц дэд бүтцийн төслийн 117.5 сая ам долларын гэрээтэй төслийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын хүрээнд тайлант хугацаанд гүйцэтгэгч компанийн дансанд 2019 оны 08 дугаар сарын 22-нд 1,042,064.59 ам доллар буюу 2,785,615.8 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэнийг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэж баталгаажуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 5 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн 5,725.4 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц дараагийн аудитаар авч үзэх асуудал гараагүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 65 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, дансны авлагын тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах гэсэн 1 зөвлөмж хэрэгжих шатанд буюу зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төсөл 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт мөнгөн гүйлгээ болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлага данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Хувь хүнээс авах 3,388.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй, ХХОАТ-ын тухай хуулийн шинэчлэлийг мөрдөж ажиллаагүйгээс цалин хөлсийг буруу тооцсоноос татварт 74.1 мянган төгрөгийн авлага, ажилтан албан хаагчдад 480.1 мянган төгрөгийн цалингийн өр үүссэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл: Холбогдох хууль зөрчигдөх, өр авлага үүсэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: ХХОАТ-ын тухай хуулийн шинэчлэлийг мөрдөж ажиллах, цаашид өр авлага үүсгэхгүй ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг цаашид мөрдөж ажиллана.

3.2 Бараа материалын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Бараа материал дансанд бүртгэлтэй 1,782.5 мянган төгрөгийн цонхны хөшиг, буйдангийн бүтээлэг, цаашид ашиглах боломжгүй болсон бичиг хэргийн материалын үлдэгдэл байгаа нь санхүүгийн тайлангийн бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

3.2.2 Эрсдэл: Санхүүгийн тайланг буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж: Цаашид ашиглах боломжгүй материалын үлдээдлийг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг цаашид мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,319,779,159.69	12,538,138,495.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	442,639,146.65	41,518,724.89
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	442,639,146.65	41,518,724.89
3121	Төгрөг	333,904.35	-
31211	Төрийн сангийн харилцах	333,904.35	
3122	Гадаад валют	442,305,242.30	41,518,724.89
31223	Арилжааны банк дахь харилцах	442,305,242.30	41,518,724.89
33	АВЛАГА	3,078,442.06	31,720,360.85
33300	Татаас, санхүүжилтийн авлага		28,060,008.77
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	197,549.41	271,676.02
335	Бусад авлага	2,880,892.65	3,388,676.06
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,880,892.65	3,388,676.06
34	УРЬДЧИЛГАА	11,870,127,990.98	12,460,965,830.03
34600	Урьдчилж гарсан зардал	11,844,878,434.98	12,460,965,830.03
3471	Урьдчилгаа тооцоо	25,249,556.00	-
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	25,249,556.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	3,933,580.00	3,933,580.00
354	Хангамжийн материал	3,933,580.00	3,933,580.00
35470	Бусад хангамжийн материал	3,933,580.00	3,933,580.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	149,612,735,733.10	151,783,492,177.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	149,612,735,733.10	151,783,492,177.10
392	Биет хөрөнгө	149,612,735,733.10	151,783,492,177.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	155,914,146.00	85,507,933.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	125,513,286.00	77,685,020.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,988,800.00	27,988,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	27,988,800.00	27,988,800.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,435,700.00	14,435,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	10,783,151.00	12,226,721.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	149,578,682,324.10	151,773,460,285.10
39301	Програм хангамж	333,000.00	333,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	333,000.00	333,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	161,932,514,892.79	164,321,630,672.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	25,249,556.00	21,029,381.96
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,249,556.00	21,029,381.96
413	Өглөг	25,249,556.00	21,029,381.96
4136	Бусад өглөг	25,249,556.00	21,029,381.96
41361	Байгууллагад төлөх өглөг	25,249,556.00	20,549,266.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		480,115.96
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	161,907,265,336.79	164,300,601,290.91
51	Засгийн газрын хувь оролцоо	161,907,265,336.79	164,300,601,290.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	87,968,839.00	87,968,839.00
51101	Өмч: - төрийн	87,968,839.00	87,968,839.00
512	Хуримтлагдсан үр дүн	161,819,296,497.79	164,212,632,451.91
51210	Өмнөх үеийн үр дүн	152,885,507,300.76	161,819,296,497.79
51220	Тайлант үеийн үр дүн	8,933,789,197.03	2,393,335,954.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	161,932,514,892.79	164,321,630,672.87

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,233,895,836.03	2,793,472,402.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,233,895,836.03	2,788,303,259.95
120	Нийтлэг татварын бус орлого	377,980,265.92	2,687,459.90
120002	Хүүгийн орлого	3,621,698.86	2,687,459.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	374,085,661.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	374,085,661.00	
120009	Бусад орлого	272,906.06	
124	Зээлийн орлого	8,855,915,570.11	2,785,615,800.05
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр	8,855,915,570.11	2,785,615,800.05
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	5,169,143.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	5,169,143.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		5,169,143.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	331,004,561.54	403,408,602.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	331,004,561.54	403,408,602.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,004,561.54	398,239,459.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,559,908.36	141,201,348.83
210101	Үндсэн цалин	235,559,908.36	141,201,348.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,645,956.40	17,641,418.60
210202	Тэтгэмжийн даатгал	27,645,956.40	17,641,418.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,000,000.00	26,640,000.00
210304	Байрны түрээс	36,000,000.00	26,640,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,192,047.54	6,015,875.23
210401	Бичиг хэрэг	1,497,210.00	2,383,900.00
210402	Тээвэр, шатахуун	6,352,130.00	3,060,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,342,707.54	571,175.23
2105	Нормативт зардал	208,900.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	208,900.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,529.60	130,473,800.31
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		130,460,186.31
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	17,529.60	13,614.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,380,219.64	76,267,017.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,802,938.64	52,245,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,577,281.00	24,021,517.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,169,143.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,169,143.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		5,169,143.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,902,891,274.49	2,390,063,799.98
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	32,938,768.54	3,272,154.14
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	32,938,768.54	3,272,154.14
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,040,846.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,040,846.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	30,897,922.54	3,272,154.14
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,933,789,197.03	2,393,335,954.12

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	9,233,622,929.97	7,856,602.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,233,622,929.97	2,687,459.90
120	Нийтлэг татварын бус орлого	377,707,359.86	2,687,459.90
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого	3,621,698.86	2,687,459.90
120009	Бусад орлого	374,085,661.00	
124	Зээлийн орлого	8,855,915,570.11	-
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр	8,855,915,570.11	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	5,169,143.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	5,169,143.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		5,169,143.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	317,112,347.13	412,249,178.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	317,112,347.13	412,249,178.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	317,112,347.13	379,020,027.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,099,831.35	110,797,398.61
210101	Үндсэн цалин	263,099,831.35	110,797,398.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	32,545,973.23
210205	Эрүүл мэндийн даатгал		32,545,973.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,802,938.64	26,640,000.00
210304	Байрны түрээс	44,802,938.64	26,640,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,342,707.54	6,015,875.23
210401	Бичиг хэрэг		2,383,900.00
210402	Тээвэр, шатахуун		3,060,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,342,707.54	571,175.23
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,514,739.60	150,775,279.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		138,584,387.72
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	17,529.60	
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		12,190,892.24
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	1,497,210.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,352,130.00	52,245,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,352,130.00	52,245,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	33,229,151.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,169,143.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		5,169,143.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	28,060,008.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		28,060,008.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,916,510,582.84	(404,392,575.90)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,855,915,570.11	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,855,915,570.11	-
2200	Дотоод эх үүсвэрээр	8,855,915,570.11	-
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	8,855,915,570.11	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,855,915,570.11)	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	32,938,768.54	3,272,154.14
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	32,938,768.54	3,272,154.14
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	32,938,768.54	3,272,154.14
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	93,533,781.27	(401,120,421.76)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	349,105,364.92	442,639,146.19
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	442,639,146.19	41,518,724.43

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	87,968,839.00		152,885,507,300.76		152,973,476,139.76
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	87,968,839.00		152,885,507,300.76		152,973,476,139.76
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн			8,933,789,197.03		
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	87,968,839.00		161,819,296,497.79		161,907,265,336.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	87,968,839.00		161,819,296,497.79		161,907,265,336.79
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
D08	Тайлант үеийн үр дүн			2,393,335,954.12		2,393,335,954.12
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	87,968,839.00		164,212,632,451.91		164,300,601,290.91

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	-	-	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	406,732,517.45	378,672,508.28	28,060,009.17	93.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	406,732,517.45	378,672,508.28	28,060,009.17	93.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	406,732,517.45	378,672,508.28	28,060,009.17	93.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	147,320,000.00	137,892,845.08	9,427,154.92	93.6
210101	Үндсэн цалин	147,320,000.00	137,892,845.08	9,427,154.92	93.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,415,000.00	17,641,418.60	773,581.40	95.8
210205	Эрүүл мэндийн даатгал	18,415,000.00	17,641,418.60	773,581.40	95.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,640,000.00	26,640,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	26,640,000.00	26,640,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,065,022.45	6,015,875.23	(950,852.78)	118.8
210401	Бичиг хэрэг	2,252,320.45	2,383,900.00	(131,579.55)	105.8
210402	Тээвэр, шатахуун	2,235,120.00	3,060,800.00	(825,680.00)	136.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	577,582.00	571,175.23	6,406.77	98.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	157,042,495.00	138,236,869.37	18,805,625.63	88.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	157,042,495.00	138,236,869.37	18,805,625.63	88.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,250,000.00	52,245,500.00	4,500.00	99.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,250,000.00	52,245,500.00	4,500.00	99.99
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		442,639,146.65	(442,639,146.65)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		41,518,724.89	(41,518,724.89)	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.02.20			САГ-2020/711/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төсөл		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Авлагыг тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, ХХОАТ-ын тухай хуулийн шинэчлэлийг мөрдөж ажиллаагүйгээс цалин хөлс буруу бодогдож өр авлага үүссэн байна.	3.942.9	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч Нягтлан бодогч	Ч.Доржготов Ч.Цэрэнбалжид
2	Цаашид ашиглах боломжгүй бараа материалын үлдэгдлийг зохих шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх	1.782.5	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч Нягтлан бодогч	Ч.Доржготов Ч.Цэрэнбалжид
Дүн		5.725.4			

